

## Хамгийн өндөр цалинтай эмзүйчидтэй улс

Ангели хэлнээс орчуулсан Г.Гийх-Оргил (хэл шинжлэлийн ухааны магистр)

ЭЗШУИС, Ерөнхий эрдмийн тэнхим

**АНУ:** Эмзүйчдийн дундаж цалин 107,000\$ - 118,000\$ харин Хөдөлмөрийн Товчооний Статистикийн 2014 оны 5 сарын мэдээгээр 118,470\$ байна. Бусад бүх мэргэжлийн дундаж цалин 47,230\$. PayScale-д дурдснаар АНУ-д эмзүйчдийн цалин газарзүйн байршил, ажилласан жил, ажил олгогчоос шалтгаалаад харилцан адилгүй байна.

**Швецарь:** Эмзүйчдийн дундаж цалин 83,600\$. PayScale-д дурдснаар, тус улсад ихэнх эмзүйчид нь 1-4 жил ажилласан туршлагатай байхад үлдсэн цөөхөн 20 хувь нь л 20 хүртэл болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байна. АНУ-тай харьцуулахад, эмзүйчдийн цалин бага ч эрүүл мэндийн халамж, аюулгүй байдал, замын хөдөлгөөн зэрэг үзүүлэлтээрээ амьжиргааны төвшин сайн улсуудын нэгд багтаж байна. Тус улс нь Numbeo-ын жагсаалтаар амьжиргааны төвшингөөрөө Дани ба Герман улсуудын дараа оржээ.

**Канад:** Эмзүйчдийн дундаж цалин 80,700\$. Цагийн дундаж цалин 33.74\$ гэхдээ ажилласан жилийн цалингийн зөрүү багатай. Ихэнх эмзүйчид нь 20 хүртэл жил ажилласныхаа дараа ажилаа солих хандлагатай байна. Канадын статистикийн мэдээгээр 2014 оны байдлаар Канадчуудын дундаж цалин 49,000\$ байна.

**Их Британи:** Эмзүйчдийн дундаж цалин 57,000\$ - 53,300\$. PayScale-д дурдснаар Их Британы эмзүйчдийн цалин 53,300\$. Харин 2014 оны Их Британы Үндэсний Статистикийн Газрын мэдээгээр 57,000\$ байна. Хотын брокерууд дундажаар 205,000\$ цалин авдагаараа хамгийн өндөр цалинтай хүмүүс болж байгаа бол онгоцны нисэгчид 138,000\$ цалин авч удаалж байна. *The Guardian*-д дурдснаар, тус улсын ерөнхий сайдын цалин 2014 онд 218,000\$ байв.

**Герман:** Эмзүйчдийн дундаж цалин 44,800\$. PayScale-д мэдээлснээр тус улсад эмэгтэйчүүд нийт эм зүйчдийн 55%-ийг эзэлдэг гэжээ. Германд эм зүйчдийг 3-аас дээш объект эзэмшихийг зөвшөөрдөггүй учраас АНУ шиг том эмийн сангийн сүлжээ төвүүд байдаггүй. *HowToGermany*-д дурдснаар, амралтын өдрүүд, бүтэн сайн өдөр, хагас сайн өдрийн үдээс хойш, ажлын өдрүүдэд, үдэш оройн цагаар ихэнх эмийн сангууд ажилдаггүй. Зарим эмийн сангууд нь 3 дах өдрүүдэд ажилдаггүй гэж бичсэн байна.